



ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА


С.НЭВТРЭХ ЗААВАР

С.НЭВТРЭХ ЗААВАР

Хэрэглэгч нэвтрэхдээ өөрийн бүртгэлтэй имэйл хаяг болон нууц үгийг ашиглан нэвтрэнэ. Мөн имэйл, нууц үгээс гадна 2FA хамгаалалтыг шаардлагатай тохиолдолд давхар оруулж нэвтрэнэ. 2FA хамгаалалт нь таны хувийн мэдээллийг илүү аюулгүй болгодог тул 2FA хамгаалалтаа идэвхжүүлэхийг зөвлөө.


1. 2FA ашиглаж нэвтрэх

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандаж **Нэвтрэх** цэсийг сонгоно.




▶ **АЛХАМ 2.**

1. **Имэйл** хэсэгт өөрийн бүртгэлтэй имэйл хаягийг бичнэ.
2. **Нууц үг** хэсэгт өөрийн зохиосон манайд нэвтрэхдээ ашигладаг нууц үгээ хийнэ.
3. **Би робот биш /I'm not a robot/** гэсэн хэсгийг чагталж гарч ирэх даалгаварыг зааврын дагуу хийж нэвтрэнэ.



▶ АЛХАМ 3. Google Authenticator:


- » 2FA код хэсэгт **Google Authenticator** апп дээрх Trade.mn холболтын 6 оронтой кодыг хийж нэвтэрнэ.



Анхааруулга: Google Authenticator апп дээрх 6 оронтой код нь 30 секунд тутамд шинэчлэгдэж байдаг тул та хугацаанд нь амжиж хийгээрэй. Мөн таны утасны цагийн тохиргоо автомат тохиргоо дээр байгаа эсэхийг нь давхар шалгаарай.


▶ АЛХАМ 4. Шинэ төхөөрөмжөөс 2FA хамгаалалттай нэвтрэх:

1. Таны бүртгэлтэй утсанд төхөөрөмж **баталгаажуулах 6 оронтой код мессежээр ирэх** бөгөөд уг кодыг код оруулах хэсэгт хийнэ.
2. 2FA код оруулна уу хэсэгт **Google Authenticator** апп дээрх Trade.mn холболтын 6 оронтой кодыг хийнэ.
3. **I'm not a robot** хэсгийг чагтлана.
4. **Баталгаажуулах** товч дээр дарж нэвтэрнэ.




2. 2FA ашиглахгүй нэвтрэх

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандаж **Нэвтрэх** цэсийг сонгоно.



▶ **АЛХАМ 2.**

1. **Имэйл** хэсэгт өөрийн бүртгэлтэй имэйл хаягийг бичнэ.
2. **Нууц үг** хэсэгт өөрийн зохиосон манайд нэвтрэхдээ ашигладаг нууц үгээ хийнэ.
3. **Би робот биш /I'm not a robot/** гэсэн хэсгийг чагталж гарч ирэх даалгаварыг зааврын дагуу хийж нэвтрэнэ.



▶ **АЛХАМ 3.** Шинэ төхөөрөмжөөс 2FA хамгаалалтгүй нэвтрэх:

1. Таны бүртгэлтэй утсанд төхөөрөмж баталгаажуулах 6 оронтой код мессежээр ирэх бөгөөд уг кодыг код оруулах хэсэгт хийнэ.
2. I'm not a robot хэсгийг чагтлана.
3. Баталгаажуулах товч дээр дарж нэвтрэнэ.

